



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/19/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахи хаягаар

АУДИТЫН ТАИЛАН

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
И-мэйл: sambuunyamyа@audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: nyamdavaan@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
"Шонхор Үнэлгээ Аудит" ХХК
Утас: 70150001
И-мэйл: Shonkhor.mn@gmail.com

Захирал: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн зорилтот түвшин

АУДИТЫН КОД:



Агуулга

| | | |
|-------|--|----|
| 1. | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. | Аудитын тайлан | 4 |
| 2.1 | Оршил | 4 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага | 5 |
| 2.3 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.4 | Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн | 6 |
| 2.5 | Дотоод хяналт | 6 |
| 2.6 | Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар | 7 |
| 2.7 | Шилэн дансны мэдээлэл | 7 |
| 2.8 | Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар | 7 |
| 2.9 | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл | 8 |
| 2.9.1 | Урт хугацаат өр төлбөр | 8 |
| 2.9.2 | Үндсэн хөрөнгө | 8 |
| 2.9.3 | Зардлын бүртгэл | 8 |
| 2.10 | Анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.11 | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд | 9 |
| 2.12 | Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 10 |
| 2.13 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 10 |
| 2.14 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл | 10 |
| 2.15 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 10 |
| 3. | Менежментийн захидал | 12 |
| 3.1 | Урт хугацаат өр төлбөрийн талаар | 14 |
| 3.2 | Үндсэн хөрөнгийн талаар | 15 |
| 3.3 | Зардлын талаар | 16 |
| 4. | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 17 |
| 4.1 | Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан | 17 |
| 4.2 | Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 18 |
| 4.3 | Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 19 |
| 4.4 | Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан | 20 |
| 4.5 | Аудит хийгдсэн зорилтот түвшний тайлан | 21 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Ч.САРАНЖАВ
ТАНАА

2018.03.15 № 06/752
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



071291

Үүрэг, хариуцлага

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын захирал Ч.Саранжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Урт хугацаат өр төлбөр, Үндсэн хөрөнгө, Зардлын талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага:


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд "Шонхор Үнэлгээ Аудит" ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Шонхор Үнэлгээ Аудит” ХХК аудитын тайланг хуулийн хугацаанд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин:

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үндсэн чиг үүрэг нь:

Эрчим хүчний салбарын найдвартай, тасралтгүй, жигд үйл ажиллагааг хангах, үйлдвэр, компаниудын техник ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих, туршилт шинжилгээгээр баталгаажуулах, мэргэжлийн зөвлөмж өгөх, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөллүүдийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангахад оршино.


Энэхүү чиг үүргийн хүрээнд дараах ажил үйлчилгээг явуулж байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавих,
- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах,
- Метал шинжилгээ, гагнуурын лаборатори”, “Химийн лаборатори”, “Цахилгааны лаборатори”-ын үйл ажиллагаа,
- Орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон танхимын сургалт,
- Ном, сонин, сэтгүүл, брошур, журнал, бүх төрлийн цаасан хэвлэлийн үйл ажиллагаа явуулж байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны хүрээнд зорилтот түвшингээ Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраар батлуулан мөрдөж ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйл, 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирлаар Ч.Саранжав 2016 онд томилогдон ажиллаж байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Гатварын тухай, Санхүүгийн бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Гатварын тухай, Санхүүгийн болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тусгай бодол, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Гатварын тухай, Санхүүгийн бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Гатварын тухай, Санхүүгийн



хүчний сайдын тушаал, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт онцгой өөрчлөлт ороогүй байна. Харин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журам батлагдсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС (НББОУС) болон бусад хуулиудыг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 оноос мөрдөн ажиллаж байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, програмд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг “Diamond” санхүүгийн програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтын тогтолцоог судлаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гүйцэтгэсэн “2015-2016 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтын тайлан”-г уншиж танилцсан.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Шалгалтын мөрөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 290 дугаар тогтоол гарч, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүрэг өгч ажилласан байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, байгууллагын дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах;
- Шилэн дансны тухай хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байршуулах;
- Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд тусгахгүй байх;
- Байгууллагын эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үндсэн үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн эзэмших;
- Зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалтыг сайжруулах;
- Байгууллагын хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоог нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;
- Эрчим хүчний яамны ашиглаж байгаа үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх асуудлыг судлаж танилцуулах;
- Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн үйлчилгээний орлогын эх үүсвэргүй болсонтой холбогдуулан 2017 оны зорилтот түвшинд өөрчлөлт хийх санал боловсруулах зэрэг болно.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын 10 эрсдэл үр нөлөөгүй байж болзошгүй гэж тооцон эдгээр эрсдлийг хянахад материаллаг эрсдэлтэй асуудал илрээгүй боловч дээрх шалгалтын тайланд тусгагдсан асуудлууд бүрэн арилаагүй байгааг аудитын асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлагад танилцуулсан болно. /ТАБ-СТА-А-5-2-оос үзнэ үү/

2.6 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их завсар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас батлан мөрдүүлж байна.

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-т шилжүүлсэн тул 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөг 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 351 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны орлого 7,130.7 сая төгрөг, зардал 6,898.7 сая төгрөгөөр батлагдсан. 2017 онд гүйцэтгэлээр 7,268.7 сая төгрөгийн орлоготой, 6,898.0 сая төгрөгийн зардалтай ажиллаж орлогын төлөвлөгөө 138.0 төгрөгөөр давж биелсэн бөгөөд зардлын хувьд 0.7 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn хуудсанд 2017 оны батлагдсан төсөв, худалдан авах төлөвлөгөө болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендерийн заруудыг байршуулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээллүүд, хөрөнгө оруулалт, тендерийн худалдан авалтын мэдээ, худалдан авах ажиллагааны тайланг оруулдаг байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-А-5-3-аас үзнэ үү/

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл


Санхүүгийн тайлангийн аудитаар аудит хийгдсэн асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Үүнд:

1. 2006 оны 1152-MON(SF) тоот Дамжуулах зээлдүүлэх гэрээгээр шилжиж ирсэн Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн 3.8 сая ам.долларын зээлийн үлдэгдлийг тухайн үеийн ханшаар нь бүртгэж 3,731.1 сая төгрөгөөр тайлагнасан нь Улсын их хурлын 2010 оны 72 дугаар тогтоолыг үндэслэсэн байна. Гэвч уг эх үүсвэрийг зарцуулсан “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн хөрөнгө оруулалт болох 3,799.5 сая төгрөгийн Дуусаагүй барилга нь “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт" (СТОУС)-ыг дагаж мөрдөнө, Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлалын 4.44 “Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт”-д “Хөрөнгө нь аж ахуйн нэгжид эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг авч ирэх магадлалтай бөгөөд түүний өртөг эсвэл үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой бол балансад тусгахаар хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, Өр төлбөр болон хөрөнгийг “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-д шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулан шилжүүлэх талаар зөвлөмж хүргүүлэх;

2. Зогсоол, полигон зэрэг 17.6 сая төгрөгийн хөрөнгийг барилга байгууламж



дансанд үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт "Авто машины зогсоол, хашаа барьсан бол газрын сайжруулалт дансанд бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол 24.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах, "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах СТ-30" тайлангаар зөрүүг зохицуулж тайлагнах, санхүүгийн програм элэгдэл зөрүүтэй бодсон тухай програмын компанид мэдэгдэж програмын шинэчлэл хийлгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

3. Үйл ажиллагааны зардлууд болох 242.8 сая төгрөгийн зардлыг мөнгө зардлагадах үед буюу мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө"-ийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зардлуудын баримт тооцоо нийлсэн актуудыг ирүүлсэн. Зардлыг аккруэл сууриар тооцож бүртгэх талаар зөвлөмж хүргүүлэх;

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хан-Уул дүүргийн татварын хэлтэсээс 2012-2016 оны санхүүгийн баримтад хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨААТҮГ-т ирүүлсэн бөгөөд үүнд нийт 1,820.9 сая төгрөгийг төлүүлэхээр тогтоосныг "Хүлээн зөвшөөрөх боломжгүй" гэж үзэж маргаан таслах зөвлөлд хандсан байна. Энэхүү татварын маргаан шийдвэрлэгдээгүй байгаа тул болзошгүй өр төлбөр гэж санхүүгийн тайлангийн тодруулгын 23 дахь хэсэг "Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр"-т тодруулга хийлгэсэн болно.

Мөн тайлант хугацааны эхэнд Урьдчилж орсон орлого дансанд "Багануурын цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх" концессийн гэрээний урьдчилгаа төлбөр болох 2016 онд орж ирсэн 600.0 мянган ам.доллар бүртгэлтэй байсан.

2017 онд энэхүү Урьдчилж орсон орлогоос орлого хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсан. Концессийн гэрээний 3.13.1.1 "Санхүүгийн хаалтын дараагаар 45 хуанлийн өдрийн дотор 600.0 мянган ам.доллар төлөгдөнө", Эрчим хүчний сайдын 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 10 дугаар тушаалын 4 дүгээр зүйлд "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдын цалин болон бусад урсгал зардал Багануурын цахилгаан станц төслийн санхүүгийн хаалтын гэрээг хийсний дараагаар Багануур Пауэр ХХК-аас концесс олгогчид олгох концессийн төлбөрийн эхний шат санхүүжилт орж ирэх хүртэлх хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэх", "НББОУС-18"-ын 19-д "Аливаа ажил гүйлгээ, үйл явдалд хамаарах орлого, зардлыг нэгэн зэрэг хүлээн зөвшөөрнө" гэснийг үндэслэн Концессийн гэрээний орлогыг "Орлого ба зардал уялдах зарчим"-ын дагуу хүлээн зөвшөөрч бүртгэхийг аудитын асуудлын бүртгэлд тусган компанийн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Эрчим хүчний сайдын 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 10 тоот тушаалаар “Багануурын цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулсан. Уг тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлыг санхүүжүүлэхийг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-т зөвшөөрсөн.

Эрчим хүчний сайдын 2017 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 35 тоот тушаалаар “Багануурын цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан бөгөөд үйл ажиллагааны зардлын төсвийг батлаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /З.Мэндсайхан/-д, санхүүжүүлэхийг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-т даалгасан.

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайханы баталсан “Багануурын цахилгаан станц” төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2017 оны үйл ажиллагааны зардлын төсөв нь нийт 1,014.2 сая төгрөгийн санхүүжилт гаргахаар батлагдсан бөгөөд үүнд 373.9 сая төгрөгөөр 2 автомашин худалдан авахаар тусгагдсан байна. Ийнхүү худалдан авсан 2 автомашин нь “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа боловч төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд ашиглагдаж байна.

Багануур, Мандалговь төсөл хэрэгжүүлэх нэгжүүд нь гэрчилгээ, дүрэм байхгүй зөвхөн “тамгатай”-гаар үйл ажиллагаа явуулдаг гэж холбогдох ажилтнууд нь тайлбарласан бөгөөд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-т харъяалагдахгүй тул бидний санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамрагдаагүй болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,084.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар 3 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитыг “Ас-Арвай Аудит” ХХК гүйцэтгэж 4 зөвлөмж өгсөн. Эдгээр 4 зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл

Төлөвлөлтийн үе шатанд нийт зарлагыг суурь болгон тооцож материаллаг байдлын түвшинг 128.2 сая төгрөгөөр тооцоолсон байсан. Гүйцэтгэлийн шатанд 2017 оны нийт хөрөнгийг суурь болгон сонгож материаллаг байдлын түвшинг 12,925.9 сая төгрөгийн нийт хөрөнгийн 1 хувиар буюу 129.3 сая төгрөгөөр тооцсон. Тус компанийн эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох эрхийг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-т шилжүүлснээр орлого, зарлагын дүнд хөдөлгөөн их орсон тул харьцангуй тогтвортой суурь болох нийт хөрөнгийг материаллаг тооцох суурь болгон сонгосон. Мөн материаллаг байдлыг тооцохдоо 2016 оны материаллаг байдлын түвшин 119.6 сая төгрөг байсныг харгалзан үзсэн болно.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6
Web: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын
захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
И-мэйл: sambuunyamya@audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
утас: 260512
И-мэйл: nyamdavaan@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
"Шонхор Үнэлгээ Аудит" ХХК
Утас: 70150001
И-мэйл: www.shonkhor.mn

Захирал: Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор Б.Эрдэнэ-Очир
Утас: 99098173
И-мэйл: erdeneochir0711@gmail.com

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1: Урт хугацаат өр төлбөр

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 1: Үндсэн хөрөнгө

Асуудал 2: Зардал

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлан, илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Энэхүү зөвлөмж танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан удирдлага болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын ажиглалт

2006 оны 1152-MON(SF) тоот Дамжуулах зээлдүүлэх гэрээгээр шилжиж ирсэн Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн 3.8 сая ам.долларын зээлийн үлдэгдлийг тухайн үеийн ханшаар нь бүртгэж 3,731.1 сая төгрөгөөр тайлагнасан нь Улсын их хурлын 2010 оны 72 дугаар тогтоолыг үндэслэсэн байна. Гэвч уг эх үүсвэрийг зарцуулсан “Эгийн голын усан цахилгаан станц” төслийн хөрөнгө оруулалт болох 3,799.5 сая төгрөгийн Дуусаагүй барилга нь “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт” (СТОУС)-ыг дагаж мөрдөнө, Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлалын 4.44 “Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт”-д “Хөрөнгө нь аж ахуйн нэгжид эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг авч ирэх магадлалтай бөгөөд түүний өртөг эсвэл үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой бол балансад тусгахаар хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл

Үнэн зөв байх, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байх.

Аудитын зөвлөмж

- Сангийн яамтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах;
- Өр төлбөр болон хөрөнгийг “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-д шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагаар гаргуулан шилжүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

Асуудал 1: Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

Зогсоол, полигон зэрэг 17.6 сая төгрөгийн хөрөнгийг барилга байгууламж дансанд үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт "Авто машины зогсоол, хашаа барьсан бол газрын сайжруулалт дансанд бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол 24.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Аудитын зөвлөмж

- Үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах;
- "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах СТ-30" тайлангаар зөрүүг зохицуулж тайлагнах;
- Санхүүгийн програм элэгдэл зөрүүтэй бодсон тухай програмын компанид мэдэгдэж програмын шинэчлэл хийлгэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Үндсэн хөрөнгө бодитой илэрхийлэгдэхгүй байх, үнэн зөв, бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байх.

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын ажиглалт

Үйл ажиллагааны зардлууд болох 242.8 сая төгрөгийн зардлыг мөнгө зардлагадах үед буюу мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг зөрчсөн.

Аудитын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг", 6.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж заасныг баримтлан орлого, зардлыг аккруэл сууриар бүртгэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Зардал бодитой илэрхийлэгдэхгүй байх, баримтын бүрдэл хангагдахгүй байх, бодитой байх, хэмжилт үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 2016.12.31 | 2017.12.31 |
|---------------|---|--------------------------|--------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,744,231,349.85 | 1,210,771,807.40 |
| 1.1.2 | Дансны авлага (Цэвэр) | 1,833,783,554.91 | 935,487,595.59 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 28,007.00 | 1,785,360.45 |
| 1.1.6 | Бараа материал | 569,261,354.40 | 275,116,816.76 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 534,763,051.50 | 50,810,282.70 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 4,682,067,317.66 | 2,473,971,862.90 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө (Цэвэр) | 7,219,720,318.63 | 10,477,545,673.69 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 59,116,660.59 | 40,624,498.48 |
| 1.2.3 | Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 7,278,836,979.22 | 10,518,170,172.17 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 11,960,904,296.88 | 12,992,142,035.07 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 71,799,363.00 | 257,628,447.74 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | 938,515.99 | 36,519,829.15 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 217,463.00 | |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 2,580,331,453.00 | 2,940,768,640.01 |
| 2.1.1.9 | Нөөц өр | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 2,653,286,794.99 | 3,234,916,916.90 |
| 2.1.2 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 3,731,110,140.00 | 3,731,110,140.00 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 3,731,110,140.00 | 3,731,110,140.00 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 6,384,396,934.99 | |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч а/ Төрийн | 2,637,320,333.16 | 2,637,320,333.16 |
| 2.3.2 | б/ Хувийн | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,075,302,847.21 | 1,075,302,847.21 |
| 2.3.8 | Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг | 993,388,457.48 | 1,073,824,953.41 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 870,495,724.04 | 1,239,666,844.39 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 5,576,507,361.89 | 6,026,114,978.17 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 11,960,904,296.88 | 12,992,142,035.07 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| Мерийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| | | 2016.12.31 | 2017.12.31 |
| 1 | Борлуулалтын орлого /цэвэр/ | 3,351,022,981.98 | 6,804,190,114.10 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (28,965,286.79) | (16,899,321.46) |
| 3 | Нийт ашиг /алдагдал/ | 3,322,057,695.19 | 6,787,290,792.64 |
| 4 | Түрээсийн орлого | 58,435,180.33 | 63,000,000.00 |
| 5 | Хүүний орлого | 42,946,810.50 | 14,704,580.07 |
| 8 | Бусад орлого | 87,181,007.48 | 296,795,303.86 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | (3,770,159,068.82) | (5,991,452,175.35) |
| 10 | Ерөнхий удирдлагын зардал | | |
| 12 | Бусад зардал | (576,000.00) | (220,434,148.00) |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз | 137,058,722.40 | (35,288,499.28) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз | (74,255,302.85) | (278,641,669.93) |
| | Бусад ашиг/алдагдал | | (270,775,892.51) |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (197,310,955.77) | 365,198,291.50 |
| 19 | Орлого татварын зардал | (3,604,416.77) | (36,519,829.15) |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (200,915,372.54) | 328,678,462.35 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг/алдагдал | | |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (200,915,372.54) | 328,678,462.35 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төрийн өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|--|-------------------------|---|------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | 2016 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 2,637,320,333.16 | 1,075,302,847.21 | 102,518,428.41 | 1,071,411,096.58 | 4,886,552,705.36 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| 3 | Залруулсан үлдэгдэл | | | | | |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | | | (200,915,372.54) | (200,915,372.54) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 890,870,029.07 | | 890,870,029.07 |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | |
| 9 | 2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,637,320,333.16 | 1,075,302,847.21 | 993,388,457.48 | 870,495,724.04 | 5,576,507,361.89 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 40,492,658.00 | 40,492,658.00 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 2,637,320,333.16 | 1,075,302,847.21 | 993,388,457.48 | 910,988,382.04 | 5,617,000,019.89 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | | | | 328,678,462.35 | 328,678,462.35 |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 80,436,495.93 | | 80,436,495.93 |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | | |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | |
| 17 | 2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 2,637,320,333.16 | 1,075,302,847.21 | 1,073,824,953.41 | 1,239,666,844.39 | 6,026,114,978.17 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ
2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| | | 2016.12.31 | 2017.12.31 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | 3,626,195,382.59 | 8,678,840,461.58 |
| | Борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 3,520,611,198.57 | 8,182,619,323.02 |
| | Туслах үйл ажиллагаанаас орсон орлого | | |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 8,491,943.00 | |
| | Бусад мөнгөн орлого | 97,092,241.02 | 496,221,138.56 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн | (3,566,502,529.19) | (5,779,085,529.08) |
| | Ажиллагсдад олгосон мөнгө | (1,891,956,338.14) | (2,351,206,119.92) |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | (356,327,094.00) | (510,350,743.55) |
| | Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө | (341,198,599.00) | (338,962,724.00) |
| | Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | (62,351,691.72) | (313,980,185.07) |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | (65,521,439.86) | (57,542,685.00) |
| | Хүүний төлбөрт төлсөн мөнгө | (1,090,476.00) | (33,154,062.00) |
| | Татварын байгууллагад төлсөн мөнгө | (195,484,110.56) | (272,358,004.00) |
| | Даатгалын төлбөрт төлсөн мөнгө | (27,076,253.80) | (55,883,932.00) |
| | Бусад мөнгөн зарлага | (625,496,526.11) | (1,845,647,073.54) |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 59,692,853.40 | 2,899,754,932.50 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | 42,946,810.50 | 14,704,580.07 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 42,946,810.50 | 14,704,580.07 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | (577,938,802.00) | (3,636,649,159.12) |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | (577,938,802.00) | (3,636,649,159.12) |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн | (534,991,991.50) | (3,621,944,579.05) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | 1,528,553,820.04 | 239,448,060.32 |
| | Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 1,386,022,783.00 | 224,018,603.38 |
| | Валютын ханшийн зөрүүгийн олз | 142,531,037.04 | 15,429,456.94 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | (5,472,314.64) | (50,717,956.22) |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | |
| | Төрөл бүрийн хандив | | |
| | Валютын ханшийн зөрүүгийн гарз | (5,472,314.64) | (50,717,956.22) |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 1,523,081,505.40 | 188,730,104.10 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,047,782,367.30 | (533,459,542.45) |
| 5 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 696,448,982.55 | 1,744,231,349.85 |
| 6 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,744,231,349.85 | 1,210,771,807.40 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

"ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ

АУДИТ ХИЙГДСЭН 2017 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

| д/д | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2017 | | Харьцуулалт | |
|-----|---|-------------|--------------------|--------------------|-------------------|--------------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт хувь |
| 1 | Нийт орлого | мян/төг | 7,130,680.0 | 7,178,690.0 | 48,010.0 | 101% |
| | Сургалтын орлого | мян/төг | 339,980.0 | 329,112.0 | (10,868.0) | 97% |
| | Техник хяналтын, төсөл хөтөлбөрийн орлого | мян/төг | 5,780,000.0 | 5,894,404.5 | 114,404.5 | 102% |
| | Зураг төсөл магадлалын орлого | мян/төг | 400,000.0 | 467,747.9 | 67,747.9 | 117% |
| | Лабораторийн хэлтэсийн орлого | мян/төг | 190,000.0 | 112,925.7 | (77,074.3) | 59% |
| | Тусгай зөвшөөрлийн орлого | мян/төг | - | - | - | - |
| | ААН-ийн нормачлалын сангийн орлого | мян/төг | - | - | - | - |
| | Борлуулалтын орлого | мян/төг | 6,709,980.0 | 6,804,190.1 | 94,210.1 | 101% |
| | Түрээсийн орлого | мян/төг | 64,200.0 | 63,000.0 | (1,200.0) | 98% |
| | Бусад орлого | мян/төг | 40,000.0 | 44,277.5 | 4,277.5 | 111% |
| | Хэвлэх цехийн орлого | мян/төг | 80,000.0 | 53,721.1 | (26,278.9) | 67% |
| | Буудлын орлого | мян/төг | 11,500.0 | 2,145.0 | (9,355.0) | 19% |
| | Energy Mongolia 2017 | мян/төг | 205,000.0 | 196,651.8 | (8,348.2) | 96% |
| | Хүүгийн орлого | мян/төг | 20,000.0 | 14,704.6 | (5,295.4) | 74% |
| | Үйл ажиллагааны орлого | мян/төг | 420,700.0 | 374,499.9 | (46,200.1) | 89% |
| 2 | Нийт зардал | мян/төг | 6,898,709.5 | 6,898,022.6 | (686.9) | 100% |
| | Үүнээс: удирдлагын зардал | мян/төг | 240,101.1 | 217,363.4 | (22,737.7) | 91% |
| 3 | Татварын өмнөх ашиг (алдагдал) | мян/төг | 231,970.5 | 365,198.3 | 133,227.8 | 157% |
| 4 | Цэвэр ашиг (алдагдал) | мян/төг | 208,773.4 | 328,678.5 | 119,905.0 | 157% |
| 5 | Төрийн өмчийн ногдол ашиг | мян/төг | 62,632.0 | 98,603.5 | 35,971.5 | 157% |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төг | 0.97 | 0.96 | (0.0) | 99% |
| 7 | Нийт авлага | мян/төг | 1,545,000.0 | 935,487.6 | (609,512.4) | 61% |
| 8 | Нийт өр төлбөр | мян/төг | 5,531,110.1 | 6,966,027.1 | 1,434,916.9 | 126% |
| 9 | Үүнээс: богино хугацаат өр төлбөр | мян/төг | 1,800,000.0 | 3,234,916.9 | 1,434,916.9 | 180% |
| 10 | Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ | мян/төг | 3,222,920.0 | 3,197,806.0 | (25,114.0) | 99% |
| 11 | Нийт ажиллагсдын тоо | тоо | 126.0 | 115.0 | (11.0) | 91% |
| 12 | Нийт цалингийн сан | мян/төг | 3,702,627.0 | 2,792,208.5 | (910,418.5) | 75% |

01
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИДГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ